

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
7 дугаар хавсралт

НИЙСЛЭЛИЙН АГААР, ОРЧНЫ БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН
2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН БИЕЛЭЛТ

2025 оны 06 дугаар сарын 10

Улаанбаатар хот

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилт от түвшин	Биелэлт	Хэрэгжилтийн хувь
1	2	4	5	6	7	8
Нэг. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ АЖЛЫН ХҮРЭЭНД						
Зорилт 1.1 Нийслэл хотын агаарын бохирдлыг 80 хувь хүртэл бууруулна. /НСТ 5.2/						
1.1.1	Агаарын бохирдлыг бууруулах агаар дахь PM2.5, PM10 тоосонцрын хэмжээг бууруулна. /НХТЖҮЧ-6.2.1, НЗДҮАХ-5.2.1.5, НХТ-4.2/	Агаар дахь PM2.5, PM10 тоосонцрын агууламж	62/99	29/47	Хүйтний улирал буюу 2025.10.01-04.01 хүртлэх Улаанбаатар хотын агаар дахь бохирдуулах бодисын сарын дундаж агууламжийг өмнөх онуудын мөн үеийн сарын дундаж агууламжтай харьцуулахад PM2.5 тоосонцор нь 53 мкг/м3-ээр буюу 16%-иар бага, азотын давхар исэл (NO2) нь 47 мкг/м3-ээр буюу 11%-иар, бага, хүхэрлэг хий (SO2) нь 68 мкг/м3-ээр буюу 16%-иар тус тус бага, PM10 тоосонцор нь 106 мкг/м3-ээр буюу 5%-иар их үзүүлэлттэй байна.	83
1.1.2	Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийг шинэчлэн тогтоож, түүнд мөрдөх журмыг баталж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. /НХТЖҮЧ-6.2.1, НЗДҮАХ- 4.2, НХТ-4.2.1/	Шинээр батлуулж хэрэгжүүлсэн журмын тоо	1	1	Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүс, бүсэд мөрдөх журмын төслийг боловсруулан, нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар 2025 оны 03 сарын 24-ний өдөр хэлэлцүүлж, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны 2025.04.23-ний өдрийн 01/1937 дугаартай журмын төсөлд санал хүргүүлэх тухай албан бичгийн дагуу Журмын төслийн 2.1.1, 2.1.9, 3.1.2,	100

					3.1.4,зэрэг заалтад тус тус саналыг тусган хамтарсан тушаал, захирамжийг баталгаажуулахаар Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд 2025 оны 05 сарын 22-ны өдөр 01/3332 тоот албан бичгээр хүргүүлж, батлагаажуулсаны дараа хэрэгжүүлэхээр бэлтгэж байна.	
1.1.3	Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд сайжруулсан түлшний нөөц бүрдүүлэх, борлуулалтын цэгээр түгээх, тээвэрлэх үйл ажиллагаанд хяналт тавина. /НХТЖҮЧ-6.2.1, НТХ-4.2/	Тээвэрлэсэн түлшний хэмжээ, тн	643,10 4	250,000	Сайжруулсан шахмал түлшний тээвэрлэлт: НЗД-ын 2024 оны "Эрх шилжүүлэх тухай" А/118 дугаар захирамжийн хүрээнд нийслэлийн 7 дүүргийн хэмжээнд 2024-2025 онд сайжруулсан шахмал түлш тээвэрлэх 30 багц ажлыг худалдан авах ажиллагааны цахим системд зарлаж, 29 багцад 27 тээврийн компанийг хуулийн хүрээнд сонгон шалгаруулж, "Сайжруулсан шахмал түлш тээвэрлэх гэрээ"-г байгуулсан. Уг ажлын хүрээнд 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрөөс 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдрийг дуустал хугацаанд 27 тээврийн компани нь зүүн болон баруун бүсийн үйлдвэрээс эцсийн борлуулалтын цэг, агуулахад нийт 542,155 тонн сайжруулсан шахмал түлшийг тасралтгүй тээвэрлэн 9,588,593,215 төгрөгийн санхүүжилт олгосон. Сайжруулсан шахмал түлшний нөөцлөлт: Нийслэлийн Засаг даргын 2024 оны "Эрх шилжүүлэх тухай" А/121 дүгээр захирамжын хүрээнд халаалтын улиралд гэр хорооллын айл өрхийн хэрэгцээнд зориулж 100 мянган тонн сайжруулсан шахмал түлшний нөөц бүрдүүлж ажиллахыг үүрэг болгосоны дагуу нийслэлийн 4, түрээсийн 44 агуулахад сонгон шалгаруулж, "Сайжруулсан шахмал түлш нөөцлөх, гурвалсан гэрээ"-г байгуулан ажилласан. 2025 оны хагас жилийн байдлаар 302 тн сайжруулсан шахмал түлшний үлдэгдэл нөөцтэй байна. Сайжруулсан шахмал түлшний борлуулалт:	100

					3.1.4,зэрэг заалтад тус тус саналыг тусган хамтарсан тушаал, захирамжийг баталгаажуулахаар Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд 2025 оны 05 сарын 22-ны өдөр 01/3332 тоот албан бичгээр хүргүүлж, батлагаажуулсаны дараа хэрэгжүүлэхээр бэлтгэж байна.	
1.1.3	Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд сайжруулсан түлшний нөөц бүрдүүлэх, борлуулалтын цэгээр түгээх, тээвэрлэх үйл ажиллагаанд хяналт тавина. /НХТЖҮЧ-6.2.1, НТХ-4.2/	Тээвэрлэсэн түлшний хэмжээ, тн	643,10 4	250,000	Сайжруулсан шахмал түлшний тээвэрлэлт: НЗД-ын 2024 оны "Эрх шилжүүлэх тухай" А/118 дугаар захирамжийн хүрээнд нийслэлийн 7 дүүргийн хэмжээнд 2024-2025 онд сайжруулсан шахмал түлш тээвэрлэх 30 багц ажлыг худалдан авах ажиллагааны цахим системд зарлаж, 29 багцад 27 тээврийн компанийг хуулийн хүрээнд сонгон шалгаруулж, "Сайжруулсан шахмал түлш тээвэрлэх гэрээ"-г байгуулсан. Уг ажлын хүрээнд 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрөөс 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдрийг дуустал хугацаанд 27 тээврийн компани нь зүүн болон баруун бүсийн үйлдвэрээс эцсийн борлуулалтын цэг, агуулахад нийт 542,155 тонн сайжруулсан шахмал түлшийг тасралтгүй тээвэрлэн 9,588,593,215 төгрөгийн санхүүжилт олгосон. Сайжруулсан шахмал түлшний нөөцлөлт: Нийслэлийн Засаг даргын 2024 оны "Эрх шилжүүлэх тухай" А/121 дүгээр захирамжын хүрээнд халаалтын улиралд гэр хорооллын айл өрхийн хэрэгцээнд зориулж 100 мянган тонн сайжруулсан шахмал түлшний нөөц бүрдүүлж ажиллахыг үүрэг болгосоны дагуу нийслэлийн 4, түрээсийн 44 агуулахад сонгон шалгаруулж, "Сайжруулсан шахмал түлш нөөцлөх, гурвалсан гэрээ"-г байгуулан ажилласан. 2025 оны хагас жилийн байдлаар 302 тн сайжруулсан шахмал түлшний үлдэгдэл нөөцтэй байна. Сайжруулсан шахмал түлшний борлуулалт:	100

					Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд 2025 оны халаалтын улиралд нийт сайжруулсан шахмал түлш борлуулагч 541 борлуулалтын цэгт сайжруулсан шахмал түлшийг ханган нийлүүлж, борлуулалтын цэгийн өдөр тутмын түлшний татан авалт, борлуулалтад хяналт тавин борлуулалтын урамшуулалын санхүүжилтийг олгож ажилласан. НЗД-ын 2025 оны "Борлуулалтын урамшуулал олгох тухай" А/142 дугаар захирамжийн хүрээнд 7 дүүргийн хэмжээнд 541 борлуулалтын цэг ажиллаж 3,312,878,800 төгрөгийн борлуулалтын урамшуулал олгосон.	
1.1.4	Уурын болон усан халаалтын зууханд магадлан итгэмжлэл хийнэ. /НХТЖҮЧ-6.2.1, НЗДҮАХ-4.2/	Хэмжилт хийсэн зуух	50	86	Уурын болон усан халаалтын зууханд магадлан итгэмжлэл хийх ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1250 дугаар захирамжаар 2024.09.15-2025.03.15 хүртлэх хугацаанд нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд магадлан итгэмжлэл хийж, мэдээллийн санг шинэчилэн ажилласан. Тус ажлын хүрээнд 100 кВт-аас дээш хүчин чадалтай 246 усан халаалтын зуух бүртгэгдсэн.	100
1.1.5	100кВт-аас дээш хүчин чадлын уурын болон усан халаалтын зууханд хяналт шалгалт хийж илэрсэн зөрчлийг арилгуулах төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийнэ.	Шалгалт хийсэн объектын тоо	30	86	Мөн БОУАӨЯ-ны 01/02, 01/09 дугаартай Төлөвлөгөөт хяналт шалгалтын удирдамжийн дагуу 100кВт-аас дээш хүчин чадалтай уурын болон усан халаалтын зуух ашиглагч нийт 75 ААНБ ,нийтийн байрны 160, нийт 235 аж ахуй нэгж байгууллагад Нийслэлийн Хяналт шалгалтын газар болон Сонгинохайрхан дүүргийн Цагдаагийн хэлтэстэй хамтран хяналт шалгалт, ашиглалтын байдал, насжилт болон нүхэн жорлонгийн судалгаа авч ажилласан байна. Уг шалгалтаар байгаль орчны үнэлгээгээр тавигдсан шаардлага биелүүлээгүй, байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй үйл	100

					ажиллагаа явуулсан, Агаарын тухай хууль, Хог хаягдлын тухай хуулийн заалтыг зөрчсөн зөрчилд Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу 20.200 нэгжийн торгууль ногдуулж улсын байцаагчийн хугацаатай албан даалгавар хүргүүлэн биелэлтэд хяналт тавин ажилласан болно. Мөн Хэмжилт, зохион байгуулалтын хэлтсээс Уурын болон Усан халаалтын зуух эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтээр 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд нийт 26 зууханд хэмжилт хийснээс Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт орших 8, Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт 8, Баянзүрх дүүргийн 6, Налайх дүүргийн нутаг дэвсгэрт 5, иргэн аж ахуйн нэгж байгууллага хамрагдсан байна. Хаягдал утааны хэмжилтийн өгөгдлүүдийг боловсруулж хэмжилтийн дүнг MNS5043:2016, MNS 5919:2009, стандартуудыг баримтлан заасан үзүүлэлттэй тус тус харьцуулан хэмжилтийн дүнг боловсруулсан байна. Хэмжилтийн үр дүнг стандарттай харьцуулахад шаардлага хангаагүй 10 зуух бүртгэгдэж, хэмжилтийн орлого 9,6 сая төгрөг буюу нийт 261 100кВт-аас дээш хүчин чадлын уурын болон усан халаалтын зууханд хяналт шалгалт хийж, нийт 29 сая төгрөг нийслэлийн төсөвт төвлөрүүлээд байна.	
1.1.6	15-100квт хүчин чадалтай халаалтын зууханд хяналт шалгалт хийж илэрсэн зөрчлийг арилгуулна.	Хяналт шалгалт хийсэн зуухны тоо	300	1333	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчын баталсан А/33 дугаартай захирамжийн хүрээнд Нийслэлийн Хяналт шалгалтын газартай хамтран 15-100кВт –ын хүчин чадалтай халаалтын зуух эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж нийт 2306 байгууллагуудад хяналт шалгалт хийж илэрсэн зөрчлийг арилгуулсан болно. Уг шалгалтын хүрээнд Байгаль орчны	100

					ажиллагаа явуулсан, Агаарын тухай хууль, Хог хаягдлын тухай хуулийн заалтыг зөрчсөн зөрчилд Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу 20.200 нэгжийн торгууль ногдуулж улсын байцаагчийн хугацаатай албан даалгавар хүргүүлэн биелэлтэд хяналт тавин ажилласан болно. Мөн Хэмжилт, зохион байгуулалтын хэлтсээс Уурын болон Усан халаалтын зуух эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтээр 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд нийт 26 зууханд хэмжилт хийснээс Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт орших 8, Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт 8, Баянзүрх дүүргийн 6, Налайх дүүргийн нутаг дэвсгэрт 5, иргэн аж ахуйн нэгж байгууллага хамрагдсан байна. Хаягдал утааны хэмжилтийн өгөгдлүүдийг боловсруулж хэмжилтийн дүнг MNS5043:2016, MNS 5919:2009, стандартуудыг баримтлан заасан үзүүлэлттэй тус тус харьцуулан хэмжилтийн дүнг боловсруулсан байна. Хэмжилтийн үр дүнг стандарттай харьцуулахад шаардлага хангаагүй 10 зуух бүртгэгдэж, хэмжилтийн орлого 9,6 сая төгрөг буюу нийт 261 100кВт-аас дээш хүчин чадлын уурын болон усан халаалтын зууханд хяналт шалгалт хийж, нийт 29 сая төгрөг нийслэлийн төсөвт төвлөрүүлээд байна.	
1.1.6	15-100квт хүчин чадалтай халаалтын зууханд хяналт шалгалт хийж илэрсэн зөрчлийг арилгуулна.	Хяналт шалгалт хийсэн зуухны тоо	300	1333	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн баталсан А/33 дугаартай захирамжийн хүрээнд Нийслэлийн Хяналт шалгалтын газартай хамтран 15-100кВт –ын хүчин чадалтай халаалтын зуух эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж нийт 2306 байгууллагуудад хяналт шалгалт хийж илэрсэн зөрчлийг арилгуулсан болно. Уг шалгалтын хүрээнд Байгаль орчны	100

					тухай багц хууль, Агаарын тухай хууль, агаарын чанарыг сайжруулах бүсийн журам зөрчсөн зөрчилд Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу 12550 нэгжийн торгууль ногдуулж улсын байцаагчийн хугацаатай албан даалгавар хүргүүлэн биелэлтэд хяналт тавин ажилласан байна.	
1.1.7	Авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоо, хяналтын цэгүүдэд түүхий нүүрс, шахмал түлшний тээвэрлэлтийн байдалд хяналтыг тавих ажлыг зохион байгуулж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.	Хяналт шалгалт хийх тээврийн хэрэгслийн тоо	-	20000	Засгийн Газрын 2018 оны 62-р тогтоол, агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журмын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд Өлзийт, Зөрлөг, Гродок, Таван толгой, Гүнт, Эмээлт, Баруун Туруун дах авто тээврийн нийт 7 шалган нэвтрүүлэх товчоодод Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газраас нийт 28 эргүүл хяналтын ажилтан 24 цагаар үүрэг гүйцэтгэн ажиллалаа. Тайлант хугацаанд 28645 тээврийн хэрэгсэлд хяналт шалгалт хийснээс агаагын чанарыг сайжруулах бүс рүү нийт 79748 тн 463кг түүхий нүүрс бүртгэн нэвтрүүлсэн байна. Үүнээс 49291 тн 622 кг түүхий нүүрс нийслэл хотоор дамжин өнгөрч, 15 удаа сайжруулсан шахмал түлш гаргахыг завдсан зөрчлийг хяналт шалгалтаар илрүүлэн, холбогдох байгууллагад шилжүүлэн ажилласан байна.	100
1.1.8	Авто замын хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгслийн хаягдал утааны болон тээврийн хэрэгслээс үүдэлтэй орчны бохирдлын агууламжийг тодорхойлох шинжилгээт хяналт шалгалт хийнэ. <i>НХТЖҮЧ-6.2.2, НЗДҮАХ-4.2.3/</i>	Шалгалт хийсэн тээврийн хэрэгслийн тоо	450	225	Байгууллагын удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын дагуу 2025 оны 03 сарын 19-ний өдөр Дашваанжил ХХК дээр газ автомашин болон бензин, дизель автомашинаас ялгарах хаягдал утаан дээр харьцуулсан хэмжилт хийсэн. Хэмжилтийн дүнгээс үзэхэд СО буюу нүүрстөрөгчийн дутуу исэл нь газ автомашин бензин автомашинаас 55 дахин бага, дизель автомашинаас 30 дахин бага байна. Мөн Нийтийн тээврийн бодлогын газар нь нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлж байгаа их багтаамжийн 1150 автобусанд агаарын чанар	Хэрэгжих хугацаа болоогүй

					хэмжигч буюу аюулгүй байдлын дохиолол өгөх зориулалтай төхөөрөмж суурилуулсан байна. Уг ажлын хүрээнд нийтийн тээврийн удирдлагын системд үүссэн дата мэдээллийг хамтран боловсруулж, мэдээлэл солилцох талаар холбогдох мэргэжилтэнтэй уулзалт зохион байгуулсан байна. Цаашид нийслэлийн тээврийн цагдаагийн албатай хамтран Автотээврийн хэрэгслийн хаягдал утааны болон тээврийн хэрэгслээс үүдэлтэй орчны бохирдлын агууламжийг тодорхойлох шинжилгээт хяналт шалгалтыг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний сийрэгжилт өндөртэй буюу 8 дугаар сард хийж гүйцэтгэхээр төлөвлөж байна. Нийтийн тээврийн үйлчилгээний их, дунд багтаамжийн тээврийн хэрэгслийг цахилгаан болон газны хэрэглээнд шилжүүлэх туршилтын ажил одоогоор эхлээгүй байна.	
1.1.9	Таван толгой түлш ХХК-ийн үйлдвэрлэсэн сайжруулсан шахмал түлш, түүний түүхий эдээс дээж авч лабораторийн шинжилгээнд хамруулж, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийнэ. /НХТЖҮЧ-6.2.1, НХТ-4.2/	Шинжилгээн д хийсэн дээж, хяналт шалгалтын тоо	37	25	Засгийн Газрын 2019 оны "Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай" 62 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 05 дугаар сарын 31-ний хүртэлх хугацаанд нийт 30 дээжид хаягдал утааны хэмжилт хийж үр дүнг (MNS5216:2016) стандарттай харьцуулсан. Хэмжилтийн үр дүнг стандарттай харьцуулахад шаардлага хангаагүй 26 түлшний дүгнэлтийг гаргаж, хэмжилтийн орлого 19,9 сая төгрөгийг нийслэлийн төсөвт төвлөрүүлээд байна. Мөн "Таван толгой түлш" ХХК-ийн сайжруулсан шахмал түлшний чанар стандартын шаардлага хангаж буй байдалд хяналт шалгалтыг Төв, Зүүн Баруун бүсийн үйлдвэрийн үйлдвэрлэсэн сайжруулсан шахмал түлшний 8, мидлингийн 3, барьцалдуулагчийн 1 дээж нийт 12 дээжинд	100

					Ашигт малтмал газрын тосны хэрэг эрхлэх газрын төв лаборатори, Хими, химийн технологийн хүрээлэнгийн итгэмжлэгдсэн лабораторид тус тус техникийн шинжилгээг хамруулахад Лабораторийн шинжилгээний сорилын дүнгээр тус дээжүүд MNS5679:2022 "Сайжруулсан хатуу түлшний техникийн ерөнхий шаардлага" стандартыг хангаж байх тул улсын байцаагчийн 7 дүгнэлт гаргаж холбогдох байгууллага, алба хаагчид тус тус хүргүүлж ажилсан болно. Мөн АЧХЗБХ-ээс Таван толгой түлш ХХК хамтран бүтээгдэхүүн болон барьцагдуулагч өөрчилсөн 18 шахмал түлшний дээжинд хаягдал утааны хийн хэмжилт хийх хүсэлт ирүүлсэний дагуу 15 дээж нь стандартын шаардлага хангаагүй, 3 дээж нь шаардлага хангасан гэсэн дүгнэлт гарсан болно. Хагас жилийн байдлаар сайжруулсан шахмал түлш, түүний түүхий эдийн нийт 60 дээж авч лабораторийн шинжилгээнд хамруулж, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж ажилласан болно.	
1.1.10	Агаар, орчны чанарт нөлөөлж болзошгүй үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагын орчны чанарт хэмжилт хийх, үнэлгээ, зөвлөмж өгнө.	Хэмжилт хийсэн тоо	30	30	Агаарын чанарыг хэмжигч явуулын харуулаар 2025 оны 01 дүгээр сарын 02-ний өдрөөс 05 дугаар сарын 31-ний өдрийн хооронд иргэн, аж ахуй нэгжийн ирүүлсэн хүсэлтийн дагуу орчны агаарын чанарын 17 хэмжилт хийж дүн мэдээг орчны агаарын чанарын MNS4585:2016 стандарттай харьцуулан боловсруулан иргэн, аж ахуй нэгжид хүргүүлж ажилласан байна. Мөн Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/402 дүгээр захирамжаар "Улаанбаатар марафон-2025" олон улсын гүйлтийг 2025 оны 05 сарын 24-ний өдөр зохион байгуулахтай холбогдуулан автозамын дагуу автомашинтай болон	70

					автомашингүй өдрийн агаарын чанарын харьцуулсан хэмжилтийг 3үүн 4-н зам орчим, Баруун 4-н зам Тэнгис кинотеатр орчим, Сансар E-mart уулзвар орчим нийт 4 цэг дээр агаарын чанарыг тодорхойлох хэмжилтийг агаарын чанар хэмжигч AQMS-9000 хөдөлгөөнт харуулаар хэмжилт хийж, хагас жилийн байдлаар нийт 21 удаагийн хэмжилт хийсэн байна.	
Зорилт 1.2. Агаар орчны бохирдлыг бууруулж, байгальд ээлтэй, үр ашигтай хэрэглээг нэмэгдүүлэх замаар эрүүл аюулгүй орчныг бүрдүүлнэ. /НХТЖҮЧ-6.2, НЗДҮАХ- 5.2./						
1.2.1	Агаарын бохирдлын хүрээлэн буй орчинд үзүүлэх хор уршиг, түүнийг бууруулах угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна./НХТЖҮЧ-6.2.2, НХТ-4.2/	Зохион байгуулах арга хэмжээ	16	10	Тус газар нь shuud.mn, news.mn, medee.mn, chig.mn, blood.mn, Үндэсний хөгжлийг дэмжих сэтгүүлчдийн зөвлөл НҮБТББ болон сайтуудтай хамтран ажиллах гэрээ байгуулан байгууллагын албан ёсны пэйж хуудсаар дамжуулан улаанбаатар хотын агаарын чанарын индексийн нийт 35 удаагийн мэдээ, угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, зөвлөмж мэдээ, мэдээллийн талаар 20 инфографик зурагт хуудас, анэймэшн хэлбэрээр бэлтгэсэн 6 видео, нийтлэл 4, сайн туршлагын талаар богино хэмжээний 1 видео контентыг тус тус бэлтгэн 78,000 гаруй иргэд олон нийтэд хүргэж ажилласан байна. Мөн MGL FM радиотой хамтран 2025.02.13-03.06 өдрийг хүртэл хугацаанд шууд эфирээр дамжуулан угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх зөвлөмж, мэдээ мэдээллийг нийт 300,000 нийт 378000 гаруй иргэд, олон нийтэд угаарын хийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээ, мэдээлэл түгээх ажлыг зохион байгуулж ажилласан байна. 2025 оны 04 дүгээр сарын 01-ны өдөр батлагдсан "Хэвлэл цахим сувгаар угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа явуулах" ажлын төлөвлөгөөний хүрээнд Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх талаар	100

					шторк, богино хэмжээний рийлс болон инфографик зурагт хуудсыг нийслэлийн 7 дүүргүүдийн Засаг даргын Тамгын газартай хамтран дүүргүүдийн хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах тасаг, хороодын ажлын албаны групп хуудасд байршуулж нийт 15000 гаруй иргэдэд хүрсэн байна. Мөн Нийслэлийн 7 дүүргийн гэр хорооллын Сайжруулсан шахмал түлш хэргэлэдэг 99 хорооны 1050 хэсгийн ахлагч нарыг Угаарын хийн эрсдэл үүсч байгаа шалтгаан нөхцөл, эрсдэлээс сэргийлэх, айл өрхийн зуух, яндангийн стандартыг хангуулах, хяналт тавьж ажиллах, аюулгүй байдлын талаар заавар зөвлөгөө өгөх, угаарын хийн мэдрэгч төхөөрөмж суурилуулах, зөв галлагааны зааварчилгаа зөвлөмж, мэдээллийн талаарх сургалтад хамруулж мөн нийт 43512 гэр хороололын айл өрхүүд, аж ахуйн нэгж байгууллагуудад угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх гарын авлага материалыг тарааж ажилласан байна.	
1.2.2	Агаарын бохирдлын хүрээлэн буй орчинд үзүүлэх хор уршиг, түүнийг бууруулах талаар нөлөөллийн ажлыг зохион байгуулна.	Тараах зөвлөмж, тоо	182,100	100.000	Тус газар нь Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамтай хамтран Агаарын чанарыг сайжруулах бүсийн айл өрхүүдийг цахилгаан болон бүх төрлийн хийн халаагуурт үе шаттай шилжүүлэхтэй холбоотойгоор ногоон бүсэд хамаарах 51,080 айл өрхийн гэр, байшингийн дулаалга ажлын хүрээнд "Дулаан байшин" амины орон сууцны нээлттэй өдөрлөгийг 2025 оны 05 дугаар сарын 4-7-ны хооронд Жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулж, нийт 12,000 гаруй иргэд олон нийтэд дулаалгын талаар танилцуулга мэдээлэл, 120000 гаруй ширхэг гарын авлага хүргэн ажилласан болно.	100

Зорилт 1.3. Агаар, орчин бохирдуулагч эх үүсвэрийг бууруулж, байгальд ээлтэй хэрэглээг нэмэгдүүлнэ./НЗДҮАХ-4.2/

1.3.1	Агаар бохирдуулагч эх үүсвэрүүд, хатуу түлшний хэмжилт хийх иж бүрэн лаборатори шинээр байгуулах бэлтгэл хангана.	Зураг төсөв хийгдсэн байна	1	1	2020-2025 онуудад агаар бохирдуулагч эх үүсвэрүүд, хатуу түлшний хэмжилт хийх иж бүрэн лабораторийн барилгыг шинээр барих хөрөнгийг шийдүүлэхээр жил бүрийн төсөвт тусгаж, санал хүргүүлсэн боловч 2025 оны төсөвт суугдаагүй тул тус ажил хойшлогдсон.	ҮБ
1.3.2	Агаар орчны хэмжилтийн тоног төхөөрөмжийг шинэчлэх, засварлана. /НХТЖҮЧ-6.2.1, НХТ-4.2/	Засаж, шинэчилсэн тоног төхөөрөмжийн тоо	-	5	Агаар орчны хэмжилтийн тоног төхөөрөмжийг шинэчлэх ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 25-ний өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/547 тоот захирамжаар "Агаар орчны хэмжилтийн тоног төхөөрөмж" худалдан авах 3 багц ажлыг Худалдан авах ажиллагааны газартай хамтран зохион байгуулж, тендер сонгон шалгаруулах зарыг 2025 оны 05 дугаар сарын 02-ний өдөр Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд (www.tender.gov.mn) байршуулж, тендерийн нээлтийг 2024 оны 05 дугаар сарын 23-ний өдөр нээж үнэлгээний хорооны хурлаар хэлэлцээд байна. 1."Дуу чимээ, үнэрийн хэмжээг тодорхойлох багаж" тоног төхөөрөмж нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийг дахин зарлаж, 1 компани оролцсон боловч шаардлага хангаагүй тул дахин нээлттэй тендер зарлаж, 2025.06.03-ний өдөр нээхээр төлөвлөж байна. 2.Автомашины хаягдал утааны хийн хэмжилт хийх багаж тоног төхөөрөмж нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулж "Ихдархчуул ХХК-тай гэрээ байгуулж, 2025.06.05-ний 01/373, 2025.06.06-ний 01/374 дугаартай албан бичгээр НЗДТГ-ийн Санхүү, хөрөнгө оруулалтын газарт баталгаажуулахаар албан бичиг тус тус хүргүүлээд байна.	100

					3.Орчны бохирдлыг хэмжих суурин төхөөрөмж нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулах эрх олгосон боловч гомдол гарсан тул гэрээ байгуулах үйл явц хүлээгдэж байна. Мөн Япон Улсын элчин сайдын яаманд 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 04/486 тоот албан бичгээр Япон Улсын буцалтгүй тусламж "Эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжих хөтөлбөр"-өөр агаарын чанарын хэмжилтийн суурин харуулын тоног төхөөрөмж шинэчлэх талаар санал хүргүүлсэн. 2025 оны 03 дугаар сарын 04-ний өдөр Япон Улсын Засгийн газар болон Монгол Улсын Засгийн газар хооронд нот бичигт гарын үсэг зуралцан буцалтгүй тусламжаар багаж төхөөрөмж нийлүүлэх 275 сая иен буюу 6,8 тэрбум төгрөгийн төсөв батлагдсан. Энэхүү ажлын хүрээнд Японы Олон улсын хамтын ажиллагааны систем (JICS)-байгууллагын төлөөлөгч нар худалдан авалтад бэлтгэхийн тулд 2025 оны 6-р сарын 17-оос 06 дугаар сарын 19-ны өдрүүдэд 6 суурин харуулын тоног төхөөрөмж, тэдгээрийн хэрхэн ажиллаж байгааг шалгах, одоо байгаа сүлжээг шалгаж, төслийн өгөгдөл дамжуулах хүрээг ярилцах, лабораторид ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжтэй танилцах чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулахаар бэлтгэл ажил хангагдаад байна.	
1.3.3	Нийслэл хотын дуу чимээ болон үнэрийн бохирдлыг бууруулах төлөвлөлт судалгааны ажил хийнэ.	Судалгааны тайлан	-	1	"Агаар орчны хэмжилтийн тоног төхөөрөмж"-ийг худалдан авах Тендер шалгаруулалтад нэг компани оролцож шаардлага хангаагүй тул дахин нээлттэй тендер зарласан. Тус тендер нь 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдөр нээлтээ хийхээр байна. Уг төхөөрөмжийг худалдан авсаны дараа буюу 3-р улиралд багтаан дуу	ҮБ

					чимээ болон үнэрийн бохирдлыг бууруулах төлөвлөлт судалгааны ажил хийгдэхээр байгаа тул уг ажил нь хэрэгжих хугацаа болоогүй байна	
1.3.4	Гэр хорооллын айл өрхийг шинэ дэвшилтэд технологид шилжүүлэх ажлын хүрээнд туршилт, судалгааны ажил хийнэ.	Судалгааны тайлан	100	50	Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар орчны бохирдлын асуудал хариуцсан орлогчийн өгсөн үүрэг даалгаврын дагуу 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдрөөс 03 дугаар сарын 26-ний өдрийг дуустал 5 өрхөд Heat pump цахилгаан халаагуурыг туршилтаар суурилуулан хэмжилт мэдээллийг гаргаж ажилласан. Мөн Динамик тауэр ХХК Польш улсын Авента компанийн үйлдвэрлэсэн эрчим хүчний хэмнэлттэй агаар сэлгэх тоног төхөөрөмжийг ХУД 20 дугаар хорооны Орхон Хасү ерөнхий боловсролын сургуульд суурилуулсан ангид төхөөрөмж ажиллах үеийн болон ажиллахгүй үеийн харьцуулсан байдлаар дотоод орчны агаар дахь нийтлэг бохирдуулагч бодисын агууламжийг тодорхойлж, нийт 1 сургууль, 14 өрхөд туршилтаар суурилуулан хэмжилт мэдээллийг гаргаж, ажилласан байна.	100
1.3.5	Хийн түлшийг хэрэглээнд нэвтрүүлэх төлөвлөлт, судалгааны ажил хийнэ.	Судалгааны тайлан	100	50	"Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын өрхөд цахилгаан халаагуур болон бүх төрлийн хийн түлшээр ажилладаг төхөөрөмж суурилуулах, тэдгээрийн хэрэглээнд үнийн урамшуулал олгох журам"-ийн төслийг боловсруулан НИТХ-ийн 2025 оны 04 дүгээр сарын 15-ний өдрийн 25/59 дугаар тогтоолоор баталуулсан болно. Журмын хэрэгжилтийн хүрээнд ногоон бүсэд 170 мянга гаруй өрх хамрагдаж байгаа бөгөөд 2025 онд 51,080 өрхийг цахилгаан болон бүх төрлийн хийн түлшний хэрэглээнд шилжүүлэн тоног төхөөрөмж, дагалдах хэрэгслийг нэг удаа үнэ төлбөргүй суурилуулж, халаалтын улиралд	90

					хэрэглээнд нь дараах байдлаар үнийн урамшуулал олгохоор төлөвлөөд байна. Мөн Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар орчны бохирдлын асуудал хариуцсан орлогчийн өгсөн үүрэг даалгаврын дагуу 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдрөөс 03 дугаар сарын 26-ний өдрийг дуустал 5 өрхөд Heat pump цахилгаан халаагуур нийт 1 сургууль, 14 өрхөд туршилтаар суурилуулан хэмжилт мэдээллийг гаргаж, ажилласан байна.	
1.3.6	Алсын зайн мэдрэгчтэй угаарын хийн мэдрэгчийг суурилуулах	Олгосон өрхийн тоо	-	51000	НЗД-ын 2025 оны 02 дугаар сарын 11-ний А/165 дугаар эрх шилжүүлэх тухай захирамжийн хүрээнд 51,000 ширхэг алсын зайн дамжуулагчтай угаарын хийн мэдрэгчийн худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар НАОБТГ-ын даргын 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн А/10 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулан худалдан авах ажиллагааг холбогдох хуулийн хүрээнд зохион байгуулсан. "Алсын зайн дамжуулагчтай угаарын хий мэдрэгч төхөөрөмж" -ийн нийлүүлэгчээр "Интеллгент технологи" ХХК нь 7,650,000,000.0 (долоон тэрбум зургаан зуун тавин сая) төгрөгийн санал ирүүлж, 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/165-1 дугаартай гэрээ байгуулсан. 51,000 ширхэг төхөөрөмжийг дагалдах хэрэгслийн хамт актаар хүлээн авч, гүйцэтгэгчийн ажлыг дүгнэж, "Түлш Хэрэглэгчдэд үйлчлэх төв" ОНӨААТҮГ-т хүлээлгэн өгч Агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын 43,750 айл өрхүүдэд суурилуулж 7,250 ширхэг угаарын хийн мэдрэгч төхөөрөмж суурьлуулаагүй байна.	100
Хоёр. Дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд						
2.1.1	Агаарын чанарын улсын хяналт-шинжилгээний сүлжээний нийслэл дэх	Агаарын чанарын	7 хоног бүр	7 хоног бүр	2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт 6 суурин харуул дээр нийт 238 удаа очиж засвар	100

	нэгжийн тасралтгүй ажиллагааг хангана. /НХТЖҮЧ-6.2.2, НХТ-4.2/	мэдээг гаргах			үйлчилгээ, стандарт хийн тохируулга, хийж ажилласан байна. Үүнээс суурин харуул тус бүрээр авч үзэхэд Баянхошуу суурин харуул дээр 39, Толгойт суурин харуул дээр 40, Нисэх суурин харуул дээр 38, Амгалан суурин харуул дээр 41, МҮОНРТ суурин харуул дээр 43, Дамбадаржаа суурин харуул дээр 37 удаа тус тус очиж ажилласан бөгөөд нийт ажилласан цаг нь 3624 цаг ажиллахаас дунджаар 3365 цаг буюу 92,8% ажилласан байна. Тус харуулуудад засвар тохируулга хийж очиж ажиллахдаа хэмжилтийн хэвийн үйл ажиллагааг хангах багажуудын тоосны фильтр солих шугам хоолойн цэвэрлэгээ хийх хэмжилт тасарсан тохиолдолд дахин ачаалуулах, стандарт хийн тохируулга хийх, багажуудын хэмжилт зогссон болон жилд солигдох сэлбэг хэрэгслийг сольх зэрэг ажлыг хийж гүйцэтгээд байна. Орчны агаарын чанарын хяналт шинжилгээ, агаар бохирдуулагч суурин эх үүсвэрийн хэмжилтийн лабораторийн үйл ажиллагааг MNS ISO/IEC 17025:2018 стандартын дагуу магадлан итгэмжлэлийг сунгуулах хүсэлтийг Үндэсний итгэмжлэлийн төвд хүргүүлж, 2025 оны 01 дүгээр сарын 28-ний өдрийн TL176 дугаартай итгэмжлэлийн гэрчилгээг авсан болно.	
2.1.2	Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд агаар бохирдуулагч эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэлийг зохион байгуулж, мэдээллийн санг шинэчлэнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	100	50	Нийслэлийн Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн А/1250 тоот захирамжийг үндэслэн "Агаар бохирдуулагч эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэл хийх ажлын удирдамжийн хүрээнд 2024 оны тоо бүртгэлээр 3-15кВт хүчин чадалтай ахуйн хэрэглээний 171,976 зуух, 16-100 кВт хүчин чадалтай 2,306 зуух, 100 кВт-аас дээш хүчин чадалтай 246 усан халаалтын зуух, Дулааны цахилгаан 6 станцын 4200 кВт-аас дээш хүчин чадалтай 41 зуух тус тус тоологдож,	100

					мэдээллийн санг шинэчлэн ажилласан. Нэгдсэн дүн мэдээг Цаг уур, орчны шинжилгээний газарт 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 01/179 тоот албан бичгээр хүргүүлэн ажилласан байна.	
2.1.3	Агаарын тухай хууль тогтоомж, стандартын дагуу орчны агаарын чанарыг хэмжигч явуулын AQMS-9000 хөдөлгөөнт харуулаар орчинд үзүүлж буй хорт нөлөөлөл орчны бохирдлын хэмжилт хийнэ.	Хэмжилт хийсэн тоо	30	25	Агаарын чанарыг хэмжигч явуулын харуулаар 2025 оны 01 дүгээр сарын 02-ний өдрөөс 05 дугаар сарын 31-ний өдрийн хооронд иргэн, аж ахуй нэгжийн ирүүлсэн хүсэлтийн дагуу орчны агаарын чанарын 17 хэмжилт хийж дүн мэдээг орчны агаарын чанарын MNS4585:2016 стандарттай харьцуулан боловсруулан иргэн, аж ахуй нэгжид хүргүүлж ажилласан байна. Мөн Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/402 дүгээр захирамжаар "Улаанбаатар марафон-2025" олон улсын гүйлтийг 2025 оны 05 сарын 24-ний өдөр зохион байгуулахтай холбогдуулан автозамын дагуу автомашинтай болон автомашингүй өдрийн агаарын чанарын харьцуулсан хэмжилтийг Зүүн 4-н зам орчим, Баруун 4-н зам Тэнгис кинотеатр орчим, Сансар E-mart уулзвар орчим нийт 4 цэг дээр агаарын чанарыг тодорхойлох хэмжилтийг агаарын чанар хэмжигч AQMS-9000 хөдөлгөөнт харуулаар хэмжилт хийж, хагас жилийн байдлаар нийт 21 удаагийн хэмжилт хийсэн байна.	84
2.1.4	Сайжруулсан хатуу түлшинд MNS 5216:2016 стандартын шаардлага хангасан эсэхэд хаягдал утааны хэмжилт хийж, улирал бүр тайлан гаргаж, холбогдох байгууллагуудад танилцуулж ажиллана.	Хэмжилт хийсэн түлшний тоо	50	50	Засгийн Газрын 2019 оны "Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай" 62 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд хагас жилийн байдлаар нийт 30 дээжид хаягдал утааны хэмжилт хийж үр дүнг (MNS5216:2016) стандарттай харьцуулсан. Хэмжилтийн үр дүнг стандарттай харьцуулахад шаардлага хангаагүй 26 түлшний дүгнэлтийг гаргаж, хэмжилтийн орлого 19,9 сая төгрөгийг нийслэлийн төсөвт төвлөрүүлээд байна.	80

2.1.5	Хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд хор, хөнөөл учруулж болзошгүй хүчин зүйлс байгаа эсэх, түүний шалтгааныг судлан тодорхойлох зорилгоор дотоод гадаад орчны агаарын бохирдолд хяналт шалгалт хийнэ.	Шалгалт хийсэн объектын тоо	-	30	Нийслэлийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан агаар, орчны бохирдлыг бууруулахад Гэр хорооллын айл өрхийн хатуу түлшний хэрэглээг бууруулж дулаан хангамжийн бусад эх үүсвэрт /төвлөрсөн дулаан, хий, сэргээгдэх эрчим хүч, цахилгаан болон бусад/ үе шаттай шилжүүлэх, агаарт үзүүлэх физикийн сөрөг нөлөөллөөс үүдэлтэй бохирдлын хэмжээг бууруулах, агаарын чанарын хяналт, шинжилгээний чадавхыг орчин үеийн түвшинд нийцүүлэх, иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлэх гэсэн үндсэн 4 заалтыг хэрэгжүүлэхэд тухайн чиглэлийн мэргэжилтнүүдийн орон тоо батлагдаагүй тул Орчны эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагчтай холбоотой хяналт хийгдээгүй байна.	ҮБ
2.1.6	"Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын дагуу Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (tender.gov.mn)-ээр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 хоногт багтаан батлуулах, тайланг төсвийн жил дууссан даруйд системээр тайлагнана.	Цахим системд тайлагнасан төсөл, арга хэмжээний тоо	2	2	2025 оны байгууллагын урсгал төсөв болон Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 10-н төсөл арга хэмжээг 62,927,99,093 төгрөгөөр хийх хэрэгжүүлэхээр Tender.gov.mn цахим системд төлөвлөгөөг баталгаажуулан, нийт 5 төсөл, арга хэмжээний сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, 5 арга хэмжээ хүлээгдэж байна.	100
2.1.7	Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, олон улсын төсөл хөтөлбөртэй хамтран ажиллах, туршлага судлах, судалгааны ажлын талаар холбогдох талуудтай хамтран ажиллана.	Хэрэгжилтийн хувь	100	50	Япон Улсын элчин сайдын яаманд 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 04/486 тоот албан бичгээр Япон Улсын буцалтгүй тусламж "Эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжих хөтөлбөр"-өөр агаарын чанарын хэмжилтийн суурин харуулын тоног төхөөрөмж шинэчлэх талаар санал хүргүүлсэн. 2025 оны 03 дугаар сарын 04-ний	100

				өдөр Япон Улсын Засгийн газар болон Монгол Улсын Засгийн газар хооронд нот бичигт гарын үсэг зуралцан буцалтгүй тусламжаар багаж төхөөрөмж нийлүүлэх 275 сая иен буюу 6,8 тэрбум төгрөгийн төсөв батлагдсан. Энэхүү ажлын хүрээнд Японы Олон улсын хамтын ажиллагааны систем (JICS)-байгууллагын төлөөлөгч нар худалдан авалтад бэлтгэхийн тулд 2025 оны 6-р сарын 17-оос 06 дугаар сарын 19-ны өдрүүдэд 6 суурин харуулын тоног төхөөрөмж, тэдгээрийн хэрхэн ажиллаж байгааг шалгах, одоо байгаа сүлжээг шалгаж, төслийн өгөгдөл дамжуулах хүрээг ярилцах, лабораторид ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжтэй танилцах чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулахаар бэлтгэл ажил хангагдаад байна. Мөн Сөүлийн үндэсний их сургуулиас хэрэгжүүлж буй "s-quad" төслийн хүрээнд холбогдох бүх зардлыг Койка ОУБ шийдвэрлэж, дэд бүтэц, байгаль орчны бодлогын талаар 5 хоногийн сайн туршлага танилцуулах хөтөлбөрт газраас 1 удирдлага, 1 мэргэжилтэн хамрагдсан болно. Мөн Агаарын бохирдлыг бууруулах, гэр хороололд амьдарч буй иргэдийн хувийн сууцны дулаан алдагдлыг багасгах хүрээнд "Дулаан шийдэл" Европын холбооны Свич-Эшиа төслийн хүрээнд 2025 оны 06 дугаар сарын 17нд 1 албан тушаалтан хамрагдахаар бэлтгэж байна. Агаарын чанарын хэмжилт, зохион байгуулалтын хэлтсээс 1 албан тушаалтан Улаанбаатар хотын гэр хорооллын айл өрхийг дэвшилтэт технологи бүхий хийн болон цахилгаан халаагуурт шилжүүлэхтэй холбогдуулан туршлага судлах зорилгоор Бүгд Найрамдах Энэтхэг Улсад 2025 оны 06 дугаар	
--	--	--	--	--	--

					сарын 17-19-ний өдрүүдэд 3 хоног, Бүгд Найрамдах Хятад Ард Улсад 2025 оны 06 дугаар сарын 20-22-ны өдрүүдэд 3 хоног ажиллахаар төлөвлөж байна.	
2.1.8	Уурын болон усан халаалтын зууханд хэмжилт хийнэ	Хэмжилт хийсэн зуух	50	38	Хагас жилийн байдлаар Уурын болон Усан халаалтын зуух эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтээр нийт 26 зууханд хэмжилт хийснээс Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт орших 8, Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт 8, Баянзүрх дүүргийн 6, Налайх дүүргийн нутаг дэвсгэрт 5, иргэн аж ахуйн нэгж байгууллага хамрагдаж, хаягдал утааны хэмжилтийн өгөгдлүүдийг боловсруулж хэмжилтийн дүнг MNS5043:2016, MNS 5919:2009, стандартуудыг баримтлан заасан үзүүлэлттэй тус бүрээр харьцуулан хэмжилтийн дүнг боловсруулж ажилласан. Уг хэмжилтийн үр дүнг стандарттай харьцуулахад шаардлага хангаагүй 10 ААНБ-ийн зууханд хэмжилт хийж, хэмжилтийн орлого 9,6 сая төгрөгийг нийслэлийн төсөвт төвлөрүүлээд байна.	80
Гурав. Хуулиар хүлээсэн нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд байгууллагын удирдлага, зохион байгуулалтыг хангана.						
3.1.1	Байгууллагын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг хангана.	Батлагдсан баримт бичгийн тоо	1	1	Газрын даргын 2025 оны А/38 дугаар тушаалаар газрын даргаар ахлуулсан Ажлын хэсэг байгуулагдаж байгууллагын засаглалын төлөв байдлыг үнэлж, засаглалын шинэчлэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах зорилгоор батлагдсан удирдамжийн дагуу байгууллагын дотоод үнэлгээг зохион байгуулж, байгууллагын дотоод үнэлгээг хийхдээ хэлтэс, тасгийн дарга удирдах ажилтнаас бүрдсэн ажлын хэсэг хуралдаж газрын төрийн захиргааны албан хаагчдын 50 хувийг оролцуулж байгууллагынхаа засаглал, үйл ажиллагааны төлөв байдлыг хамтран хэлэлцэж үнэлсэн болно.	75

					Мөн үнэлгээг хийхдээ үнэлгээний асуулга тус бүрд шаардлагатай баримт бичиг болох байгууллагын дүрэм, Чанарын менежментийн тогтолцооны гарын авлагыг ашиглаж холбогдох судалгаа, баталсан дүрэм, журмын хэрэгжилтийн байдалд тулгуурлан үнэлж, 124 асуултын хүрээнд холбогдох баримт бичгийн хамт, 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 01/239 дугаартай албан бичгээр НЗДТГ-ийн холбогдох хэлтэст хүргүүлж ажилласан. Байгууллагын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөний төслийг боловсруулж, батлуулахаар бэлтгэл ажил хангагдаад байна.	
3.1.2	Төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлж дүгнэх, үнэлгээнд үндэслэн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	Хэрэгжилт, хувь	100	50	Төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлж дүгнэх үнэлгээний баг байгуулах тухай 2025 оны 06 дугаар сарын 05-ний өдрийн А/67 дугаартай тушаалаар Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх, Төрийн албаны тухай хуулийн 7.1 дэх хэсэгт заасаны дагуу хагас, бүтэн жилээр дүгнэх ажлыг зохион байгуулах ажил хийгдэж байна.	100
3.1.3	Байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн судалгааг улирал бүр хийж, түүний мөрөөр авах арга хэмжээг зохион байгуулна.	Зохион байгуулсан арга хэмжээ, тоо	4	4	Байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн судалгааг 2,3-р улиралд багтаан авахаар бэлтгэж байна.	70
3.1.4	Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхэд хууль, зүйн үндэслэлтэй нэг мөр эцэслэн шийдвэрлэх, хариуг албан ёсоор өгч хэвших, өргөдөл гомдлын хугацаа зөрчлийн үзүүлэлтийг бууруулах, шийдвэрлэлтийг сайжруулах чиглэлээр тусгайлсан арга хэмжээ авч хэрэгжилтийг хангаж ажиллана.	Хэрэгжилт, хувь	100	50	Хагас жилийн байдлаар байгууллагын хэмжээнд нийт 161 өргөдөл, гомдол ирүүлснээс судлагдаж буй 1, хугацаанд нь шийдвэрлэсэн 160, албан бичгээр хариу өгсөн 6, мессежээр хариу өгсөн 69, утсаар хариу өгсөн 77, иргэнтэй биеэр уулзаж хариу хүргүүлсэн 8 байна. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 9 хоног 13 цаг 55 минут байна. Байгууллагын хэмжээнд нийт 9 зөрчил бүртгэгдсэнээс өдөрт нь багтаан хүлээн	100

					аваагүй зөрчил 5, явцын тэмдэглэл хөтлөөгүй 4 зөрчил бүртгэгдэн, цаашид зөрчил гаргахгүй байх чиглэлээр арга хэмжээ авч ажиллаж байна.	
3.1.5	Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулж, өр авлага үүсгэхгүй байх, төсвийн гүйцэтгэлийг хуулийн хугацаанд тайлагнаж ажиллана.	Хэрэгжилт, хувь	100	50	Батлагдсан төсөв, төсвийн сар, улирлын хуваарь: 2024 оны 12 дугаар сарын 25-ний өдрийн Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 24/33 дугаар тогтоолоор 2025 онд нийт 58,443,946,000 төгрөгийн төсөв батлагдсан. Үүнээс - Цалин, хөлс болон нэмэгдэл, урамшуулал, унааа хоол, нийгмийн даатгалын шимтгэлд -1,827,399,500 төгрөг - Байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд- 79,192,100 төгрөг - Хангамж, бараа материалын зардалд - 38,497,730,400 төгрөг - Эд хогшил, урсгал засварын зардалд - 180,495,700 төгрөг - Төлбөр хураамжийн зардалд - 635,868,300 төгрөг - Бараа үйлчилгээний бусад зардалд - 3,500,000 төгрөг - Нэг удаагийн тэтгэмж урамшуулал, шагналын зардалд - 12,000,000 төгрөг - Сайжруулсан шахмал түлш борлуулах борлуулалтын цэгүүдийн урамшуулалд - 9,527,760,000 төгрөг - Сайжруулсан шахмал түлшийг тээвэрлэх тээврийн зардалд -38,435,100,000 төгрөг - Сайжруулсан шахмал түлшийг нөөцлөх агуулахын түрээсийн зардалд - 7,680,000,000 төгрөгийг тус тус төлөвлөж сар, улирлын төсвийн хувиарыг төсвийн	100